

Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын

хамтын ажиллагааны хөтөлбөрийн товч танилцуулга

Монгол Улсын Засгийн газар болон Австрали Улсын Засгийн газрын хооронд **“Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр”**-ийн тухай дэд гэрээг 2015 онд 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр байгуулсан. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын хөгжлийг дэмжих, Монгол Улсын иргэд эрдэс баялгийн салбарын үр шимийг хүртээмжтэй, тогтвортой байдлаар хүртэх боломжийг бий болгоход хувь нэмэр оруулахад чиглэгдэнэ.

Австрали Улсын Гадаад Харилцаа, Худалдааны Яам нь Адам Смит Интернэйшнл компанийг энэхүү хөтөлбөрийн хэрэгжүүлэгчээр сонгон шалгаруулсан бөгөөд энэхүү хөтөлбөрт тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Тус хөтөлбөр нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарын бодлого, зохицуулалт, засаглалыг дэмжих, хамтран ажиллагч талуудын түншлэлийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2015-2016 онуудад Ашигт малтмал, газрын тосны газарт дараах техникийн туслалцааны төслүүдийг хэрэгжүүлсэн.

- **Ашигт малтмал баяжуулах үйлдвэрүүдийн аюулгүй ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулсан.**

Энэхүү журам нь Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн аюулгүй ажиллагааг сайжруулахад хувь нэмэр оруулж, аюулгүй ажиллагааны зөрчлийг багасгах, урьдчилан сэргийлэх, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах болно. Энэхүү журмыг шинэчлэх ажлыг Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Геологи, Уул уурхайн сургуультай хамтран хийсэн.

- **Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх аргачлалыг боловсронгуй болгох:**

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг олон улсын хүлээн зөвшөөрөгдсөн аргачлалаар хийх нь аливаа маргаан, эрсдэлээс сэргийлэх, түүнчлэн Монгол Улс эрдэс баялгийн салбараас олох татварыг урьдчилан тооцох, төлөвлөхөд ач холбогдолтой. Энэхүү ажлыг Олон улсын болон дотоодын зөвлөхүүд хийж гүйцэтгэсэн бөгөөд дараах тайланг боловсруулсан.

- i. *Олон улсын түвшинд болон Монгол Улсад ашигт малтмалын үнэлгээ хийж буй код, аргачлалын талаарх судалгааны тайлан*
- ii. *Монголын ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийх удирдамжын төсөл*

- **Ашигт малтмал, газрын тосны газрын зүгээс олон нийтэд эрдэс баялгийн салбарын талаар иж бүрэн, хүртээмжтэй, ашиглагдахуйц мэдээлэл түгээхэд нь дэмжлэг үзүүлэн ажилласан.** Энэхүү харилцаа холбооны стратеги нь уул уурхайн салбарын бодлогийг үндэсний хэмжээнд үр дүнтэй хэрэгжүүлэх, ажил хэрэгч хамтын

ажиллагаа бий болгоход түлхэц болох юм. Энэхүү ажлыг Монголын Уул Уурхайн сэтгүүл (Mongolian Mining Journal) хийж гүйцэтгэсэн.

- **Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 300 аж ахуйн нэгжийн 500 гаруй ажилтанд хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг АМГ-ын цахим тайлангийн систем ашиглан хүргүүлэх тухай сургалтыг зохион байгуулсан.**

Энэхүү сургалтыг тус цахим тайлангийн системийг хөгжүүлэгч Смарт Грийн Технологи компани хариуцан гүйцэтгэсэн бөгөөд хайгуулын ажлын төлөвлөгөө, тайланг цахим хэлбэрээр хүлээн авдаг болсоноор цаг, зардал хэмнэхэд хувь нэмэр оруулна.

АМЕР хөтөлбөрийн зүгээс 2017 онд АМГТ-т Эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн сан байгуулахад техникийн туслалцаа үзүүлэхээр төлөвлөж байна. Энэхүү хүрээнд хийгдэх анхны ажил нь Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа интернетэд суурилсан каталогийн систем (WebGIS) боловсруулах явдал юм. Энэхүү каталогийг боловсруулсанаар хэрэглэгчид мэдээллийн хураангуйг шаардлагатай шүүлтүүрээр хайж үзэх боломжтой болно.